



# MIRIM

INNOVATION & CONSULTANT

*Chw. Tour. Bymssur.*



MIRIM



INNOVATION & CONSULTANT



# БИДНИЙ ТУХАЙ

МИРИМ Консалтант нь 2013 онд үүсгэн байгуулагдсан **бизнес, инновацийн** зөвлөх үйлчилгээний компани юм. Бид зах зээл, бизнес хөгжлийн судалгаа, зөвлөх үйлчилгээ, сургалт, дата менежмент, бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн чиглэлээр бизнесийн, төрийн болон төрийн бус, олон улсын байгууллагуудад үйлчилгээ үзүүлдэг.

Бизнесийн судалгаа, зөвлөх үйлчилгээний тэргүүлэгч байгууллага болох зорилгынхоо хүрээнд бизнесийн төрөл бүрийн судалгаа, зөвлөх үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд чанартай гүйцэтгэж ирсэн бөгөөд экспортын зөвлөх үйлчилгээ, их өгөгдөл, түүний дүн шинжилгээнд тулгуурласан бизнесийн шийдвэр гаргалт, тогтвортой хөгжлийг дэмжсэн бизнесийн судалгаа, зөвлөх үйлчилгээнд илүүтэй төвлөрч байна.

Шинэ мэдлэг, холч шийдэлтэй зөвлөх үйлчилгээг харилцагчиддаа хүргэж, хамтдаа хөгжих эрхэм зорилготойгоор бид ажиллаж байна. Бид харилцагч нартаа мэргэжлийн судалгаанд түшиглэн үр ашигтай шийдэл, онцлогт нь тохирсон бодит хэрэгжих зөвлөгөөг санал болгохоос гадна харилцан итгэлцэл, ёс зүйн зарчмыг үргэлж баримталдаг.

## АЛСЫН ХАРАА

Бизнесийн судалгаа, зөвлөх үйлчилгээний тэргүүлэгч байгууллага байна.

## ЭРХЭМ ЗОРИЛГО

Шинэ мэдлэг, холч шийдэлтэй зөвлөх үйлчилгээг хүргэж, хамтдаа хөгжинө.

## ҮНЭТ ЗҮЙЛС

### Бүтээлч:

- Мэргэжлийн судалгаанд түшиглэж, харилцагч нартаа үнэ цэнийг бий болгоно.
- Үр ашигтай шийдэл, бодитой хэрэгжих зөвлөгөөг санал болгоно.

### Итгэлцэл:

- Зөвлөх үйлчилгээний үндэсний болон олон улсын стандартыг мөрдөнө.
- Судалгааны ёс зүйг баримталж, мэдээллийн нууцлалыг чандлан хадгална.

### Монгол туршлага:

- Монголын онцлог, орчин нөхцөлд тохирсон шийдлийг санал болгоно.

Бид судалгаа, зөвлөх үйлчилгээний үе шат бүртээ дотоод чанарын хяналт, судалгааны ёс зүйг чанд мөрдөн ажиллахын зэрэгцээ дотоодын болон олон улсын стандарт, шаардлагуудыг баримтлан ажилладаг.

### Бидний мөрдөж буй стандартууд:

- ISO 200700:2017  
Менежментийн зөвлөх үйлчилгээний зөвлөмж
- ISO 20252:2012  
Зах зээл, олон нийтийн санаа бодол, нийгмийн судалгаа, нэр томъёоны тайлбар толь, үйлчилгээнд тавих шаардлага

### Үйлчилгээндээ баримталдаг тэргүүлэх зарчим:

- Мэргэжлийн судалгаа
- Бүтээлч гүйцэтгэл
- Урт хугацааны түншлэл

# БИДНИЙ ҮЙЛЧИЛГЭЭ



## СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ



### 1. Бизнесийн судалгаа

Салбарын судалгаа  
Зах зээлийн судалгаа  
Хэрэглэгчийн судалгаа  
Өрсөлдөгчийн судалгаа  
Маркетингийн судалгаа  
Маркетингийн хөндлөнгийн хяналт үнэлгээ  
Байгууллагын орчны судалгаа

### 2. Эдийн засгийн судалгаа ба загварчлал

Макро эдийн засгийн судалгаа ба загварчлал  
Микро эдийн засгийн судалгаа ба загварчлал  
Тогтвортой хөгжил ба ногоон эдийн засгийн судалгаа

### 3. Экспортын судалгаа ба зөвлөх үйлчилгээ

Экспортын зах зээлийн орчны судалгаа  
Экспортын зах зээлийн хэрэглэгч ба өрсөлдөгчийн судалгаа  
Экспортын бараа, үйлчилгээний маркетингийн судалгаа

### 4. Сонгуулийн судалгаа

Рейтингийн судалгаа  
Зорилтот бүлгийн хэрэгцээг тодорхойлох  
Кампанит ажлын үйл ажиллагааны мониторинг  
Хэвлэлийн болон сошиал медиа мониторинг

## ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ



### 1. Менежментийн зөвлөх үйлчилгээ

Стратеги төлөвлөгөө ба зөвлөгөө  
Процессийн шинжилгээ, төлөвлөлт, зөвлөгөө  
Хүний нөөцийн судалгаа, төлөвлөгөө, зөвлөгөө

### 2. Экспорт ба импортын зөвлөх үйлчилгээ

### 3. Бизнесийн зөвлөх үйлчилгээ

Бизнес төлөвлөгөө ба зөвлөгөө  
Маркетингийн төлөвлөгөө ба зөвлөгөө  
Санхүүгийн төлөвлөгөө ба зөвлөгөө  
Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө ба зөвлөгөө

### 4. Техник эдийн засгийн үндэслэл



## СУРГАЛТ

1. Бизнесийн удирдлагын сургалт
2. Хүний нөөцийн ур чадварын сургалт
3. Судалгааны арга зүйн сургалт



## ДАТА МЕНЕЖМЕНТ

1. ИНГҮМЭЛ платформ
2. Мэдээллийн сан бүрдүүлэлт
3. Их өгөгдлийн шинжилгээ



## БРЭНД СУДАЛГАА

1. Нээлттэй мэдээллийн сангийн бүтээгдэхүүн хөгжүүлэлт
2. Уул уурхайн хөрөнгө оруулалтын бодлогын индекс

# СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ

Бид **эдийн засаг, бизнес, маркетингийн** бүх төрлийн судалгааг гүйцэтгэдэг. Өнгөрсөн хугацаанд банк санхүү, харилцаа холбоо, барилга, уул уурхай, ХАА, боловсруулах үйлдвэрлэл, худалдаа, боловсрол, эрүүл мэнд, аялал жуулчлал зэрэг бүхий л салбарт судалгаа, шинжилгээний ажил хэрэгжүүлж туршлага хуримтлууллаа. Манай компани **ХАА болон боловсруулах үйлдвэрлэлийн** салбарт илүүтэй төвлөрч, салбарын суурь мэдээллийн санг үүсгэн ажиллаж байна. Судалгаа, шинжилгээний ажлууд манай байгууллагын гүйцэтгэж байгаа ажлын **70+** хувийг эзэлдэг.

Бид аливаа судалгааг хийхдээ баталгаатай эх сурвалжаас судалгааны мэдээллийг цуглуулж, орчин үеийн аргагүй болон гүнзгийрүүлсэн дүн шинжилгээнд суурилахын сацуу тоон болон чанарын судалгааны аргыг хослуулан ашигладаг.

Бид үндсэн 4 чиглэлээр судалгаа, шинжилгээний ажил гүйцэтгэж байна.

## 1. БИЗНЕСИЙН СУДАЛГАА

Бид бизнесийн салбарын онцлог, том, дунд, жижиг аж ахуй нэгжүүд, тэдгээрийн бизнесийн мөчлөгийн өсөлт, уналтын талаар арвин их мэдлэг, туршлагыг хуримтлуулаад байна. Энэхүү мэдлэг, туршлагадаа үндэслэн бид харилцагч нартаа мэргэжлийн судалгаанд суурилсан бодит үр дүн, үр ашигтай шийдлийг санал болгохыг ямагт хичээн ажилладаг юм. Манай компани нийт **40+** бизнесийн судалгааны төслийг амжилттай хэрэгжүүлээд байна.

### Салбарын судалгааны туршлага:

Бид банк санхүү, барилга, харилцаа холбоо, эрчим хүч, аялал жуулчлал зэрэг салбарыг бүхэлд нь хамарсан судалгааг хэрэгжүүлэхийн зэрэгцээ жижиг дунд бизнес, түрээсийн харилцаа, ногоон байгууламж, ногоон барилга, үнэт эдлэл, барилгын материал, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, төрийн худалдан авалт, худалдаа үйлчилгээний төв, сүлжээ дэлгүүр, татваргүй барааны дэлгүүр, бизнесийн ёс зүйт байдал зэрэг дэд салбар болон тухайлсан сэдвээр олон тооны судалгааны ажил хэрэгжүүлж, туршлага хуримтлуулаад байна.

### Бараа, үйлчилгээний зах зээлийн туршлага:

Бид зайрмаг, коктейль, цэвэр ус, мах махан бүтээгдэхүүн, бичгийн цаас, шатахуун, компьютер, цай шоп үйлчилгээ, автомашины хөдөлгүүр халаагч, сарлагийн хөөврөн бүтээгдэхүүн, ноос ноолууран бүтээгдэхүүн, уран баримал, хүүхдийн контент, гурвалсан үйлчилгээ (IPTV) зэрэг олон төрлийн бараа үйлчилгээний зах зээлийн судалгааг хэрэгжүүлээд байна.







## Хэрэглэгчийн судалгааны туршлага:

Бид хэрэглэгчийн худалдан авах чадвар, зан төлөв, сэтгэл ханамжийн судалгааг Улаанбаатар хотын болон 21 аймгийн өрхүүд, тухайлсан ААНБ болон тодорхой бараа үйлчилгээний хэрэглэгчдийн хувьд хийж байна. Давхардсан тоогоор нийт 30,000+ хэрэглэгч болон өрхүүд манай судалгаануудад хамрагдсан бөгөөд бид томоохон бизнесийн байгууллагуудын хэрэглэгчийн судалгааг тогтмол давтамжтайгаар хэрэгжүүлж ирлээ.

## Маркетингийн судалгаа ба хяналт үнэлгээний хүрээнд:

Орчин үеийн арга техникүүдийг ашиглан маркетингийн судалгаа болон хяналт үнэлгээний ажлаа хэрэгжүүлж байна. Бид тухайн бараа, үйлчилгээний зах зээлд эзлэх байр суурь, сегмент, хэрэглэгчийн ойлголт, хандлага, өрсөлдөгчдийн үйл хөдлөлийг нарийвчлан судлахын зэрэгцээ зах зээлийн гүйцэтгэлд хөндлөнгийн хяналт хийж байна.

## 2. ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГАА БА ЗАГВАРЧЛАЛ

Бид эдийн засгийн судалгаа тэр дундаа загварчлалын чиглэлд илүүтэй төвлөрөн ажиллаж, эдийн засгийн судалгаа, шинжилгээг ахисан түвшинд гүйцэтгэж байна. Манай компани нийт **15+** эдийн засгийн судалгаа ба загварчлалын томоохон ажлыг амжилттай хэрэгжүүлээд байна.

### Макро эдийн засгийн хүрээнд

- Эдийн засгийн салбарын судалгаа
- Макро эдийн засгийн төлөв байдлын судалгаа
- Бизнесийн мөчлөгийн шинжилгээ
- Төсөв, мөнгөний бодлогын шинжилгээ болон тэдгээрийн уялдаа
- Гадаад сектор ба төлбөрийн тэнцэл

гэсэн чиглэлүүдээр судалгаа, шинжилгээний ажлыг хэрэгжүүлж байна.

Бид баруун бүсийн нийгэм, эдийн засгийн судалгаа, хөтөлбөрт суурилсан төсөв, инфляцийн талаарх олон нийтийн хүлээлт, түрээсийн харилцааны нийгэм эдийн засгийн судалгаа, албан бус секторын нийгэм, эдийн засгийн судалгаа, бичил уурхай эрхлэгчдийн эдийн засагт оруулж буй хувь нэмэр зэрэг томоохон судалгааны ажлуудыг амжилттай гүйцэтгээд байна.

### Микро эдийн засгийн хүрээнд

- Эрэлт, нийлүүлэлтийн шинжилгээ ба таамаглал
- Үйлдвэрлэл, зардал, ашгийн шинжилгээ
- Өрсөлдөөний шинжилгээ ба зах зээлийн бүтэц
- Зардал, үр ашгийн шинжилгээ

гэсэн чиглэлүүдээр судалгаа, шинжилгээний ажлыг хэрэгжүүлж байна.

Бид олон зах зээлийн хувьд эрэлт, нийлүүлэлтийг тодорхойлж, тэдгээрийн хэтийн төлөвийг тооцохын зэрэгцээ улсын хэмжээнд нийт 80 гаруй зах зээлийн бүтэц, өрсөлдөөний хэлбэрийг тодорхойлсон.

### 3. ЭКСПОРТЫН СУДАЛГАА БА ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ

Экспортын судалгаа ба зөвлөх үйлчилгээ нь манай компанийн стратегийн үндсэн чиглэлүүдийн нэг бөгөөд бид энэ салбарт ихээхэн анхаарч ажиллаж байна.

Экспортын судалгаа болон зөвлөх үйлчилгээг хийхдээ бид аль зах зээлд бараа, үйлчилгээгээ гаргах уу гэдгээс эхлээд зорилтот зах зээлийн орчин, хэрэглэгч, өрсөлдөгчийг нарийвчлан судалж, улмаар шинэ зах зээлд нэвтрэх боломж, эрсдэл, стратегийг тодорхойлдог.


Судалгааныхаа үр дүнд үндэслэн экспортын хөгжлийн төлөвлөгөөг боловсруулж, **зуучлалын үйлчилгээ буюу гадаад зах зээлтэй холбох үйлчилгээг** хэрэгжүүлж байна. Одоогоор бид ноос ноолууран бүтээгдэхүүн, хоёрдогч түүхий эдийн экспортын судалгаа ба зөвлөх үйлчилгээ, хүнсний бүтээгдэхүүний импортын зөвлөх үйлчилгээг үзүүлээд байна.

Экспортын судалгаа ба зөвлөх үйлчилгээгээрээ дамжуулан АНУ, Япон, Канад, Африкийн улс орнууд руу гарцтай болох анхны алхмыг нээж, зуучлалын үйлчилгээг нэвтрүүлэхийн зэрэгцээ зорилтот улс бүрээр экспортын цахим мэдээллийн санг бүрдүүлж эхлээд байна.

### 4. СОНГУУЛИЙН СУДАЛГАА

Манай компани Ерөнхийлөгч, УИХ, орон нутгийн сонгуульд нэр дэвшигчид болон намын захиалгаар **рейтинг, олон нийтийн санаа бодол, зорилтот бүлгийн хэрэгцээг тодорхойлох судалгаа, кампанит ажлын үйл ажиллагааны мониторинг, хэвлэл болон сошиал медиа мониторингийн** ажлыг гүйцэтгэж ирсэн.

Бид **20+** сонгуулийн судалгааг амжилттай хэрэгжүүлсэн бөгөөд судалгаа бүрийн үр дүн сонгуулийн бодит үр дүнтэй бүрэн нийцсэн нь бидний ажлын чанар, үр нөлөөг илтгэж байна. Бид энэ амжилтаа улам ахиулж, сонгуулийн олон улсад ашиглагдаж буй шинэлэг арга, техникийг нэвтрүүлэх, сонгогчдыг нарийвчлан сегментчлэх ажлыг хэрэгжүүлж байна.





# ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ

Бид мэргэжлийн судалгаанд суурилсан менежментийн болон бизнесийн зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлдэг. Аливаа зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэхдээ нарийвчилсан оншилгоо, ул суурьтай судалгаа, шинжилгээг заавал урьдчилан хэрэгжүүлэхээс гадна тухайн орчин нөхцөлд тохирсон зөвлөгөөг өгч ажилладаг.

Дараах үндсэн 2 төрлөөр зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлж байна.

## 1. МЕНЕЖМЕНТИЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ

Бид тухайн байгууллагын үйл ажиллагаа, нөөц боломж, соёлын онцлогт нийцүүлэн судалгаа, шинжилгээ болон сургалттай хослуулан менежментийн зөвлөх үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд хүргэж байна.

Манай компани нийт **15+** менежментийн зөвлөх үйлчилгээг амжилттай хэрэгжүүлээд байна. Салбартаа тэргүүлэгч групп компаниас эхлээд жижиг дунд ААНБ, орон нутгийн бизнес эрхлэгч, хоршоод, нөхөрлөл зэрэг төрөл бүрийн байгууллагад менежментийн зөвлөх үйлчилгээг үзүүлээд байна.

Менежментийн зөвлөх үйлчилгээний хүрээнд:

- Стратеги төлөвлөгөө ба зөвлөгөө
- Процессийн шинжилгээ, төлөвлөлт, зөвлөгөө
- Хүний нөөцийн судалгаа, төлөвлөгөө, зөвлөгөө гэсэн чиглэлээр ажиллаж байна.

## 2. БИЗНЕСИЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ

Бид тухайн байгууллагын дотоод болон гадаад орчин, түүний нөлөөллийг сайтар судалсаны үндсэн дээр бизнесийн зөвлөх үйлчилгээгээ мэргэжлийн өндөр түвшинд хүргэж байна. Манай компани нийт **20** гаруй бизнесийн зөвлөх үйлчилгээг амжилттай хэрэгжүүлсэн бөгөөд бүх түвшний байгууллагуудад болон Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк, Дэлхийн Банкны “Экспортын Дэмжих Төсөл”-ийн тэтгэлэгт амжилттай хамрагдсан ААНБ-дад зөвлөх үйлчилгээгээ хүргээд байна.

Бизнесийн зөвлөх үйлчилгээний хүрээнд:

- Бизнес төлөвлөгөө ба зөвлөгөө
- Маркетингийн төлөвлөгөө ба зөвлөгөө
- Санхүүгийн төлөвлөгөө ба зөвлөгөө
- Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө ба зөвлөгөө гэсэн чиглэлээр ажиллаж байна.



# СУРГАЛТ

Бид бизнесийн үйл ажиллагааг дэмжих болон сайжруулахад чиглэсэн **бизнесийн удирдлага, хүний нөөцийн сургалт** явуулахаас гадна **судалгааны аргазүйн сургалтуудыг** зохион байгуулдаг.

Манай сургалт аж ахуйн нэгжийн бизнесийн үйл ажиллагаа, менежментэд тулгарч буй асуудлыг судлан илэрүүлж, асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай онолын мэдлэг болон ажлын байранд хэрэгжүүлэх арга барил, дадалыг олгодоогоороо онцлогтой. Түүнчлэн бид салбар бүртээ амжилттай бизнес эрхэлж яваа, арвин туршлагатай багш нартай хамтран ажилладаг.

Бид сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулахдаа оролцооны, интерактив аргачлал ашигладаг ба зохион байгуулалт, оролцогчдын хэрэгцээний үнэлгээ, сургалтын материал зэргийг оролцогчдын онцлогт тохируулан бэлтгэж, сургалт бүрийн төгсгөлд сэтгэл ханамжийн судалгаа хийж, үр дүнг үнэлдэг. Оролцогчдод сертификат олгож, гарын авлага, материалаар хангадаг.



*Манай бизнест бодитоор хэрэгжих мэдлэгийг  
Бид олгоно.*

## 1. БИЗНЕСИЙН УДИРДЛАГЫН СУРГАЛТ

Бизнесийн удирдлагын сургалт нь ААНБ-ын бизнес эрхлэх, бизнесээ хөгжүүлэх чадавхийг бэхжүүлэхэд голлон төвлөрч байна. Бид **10+** бизнесийн удирдлагын сургалтыг ААНБ болон бизнес эрхлэгчдэд амжилттай хэрэгжүүлээд байна.

Бизнесийн удирдлагын сургалтын хүрээнд:

- Байгууллагын менежмент ба стратеги төлөвлөгөө боловсруулах
- Бизнес төлөвлөгөө боловсруулах
- Маркетингийн стратеги ба төлөвлөгөө боловсруулах
- Санхүүгийн менежмент гэсэн чиглэлээр сургалтыг зохион байгуулж байна.

## 2. ХҮНИЙ НӨӨЦИЙН МЕНЕЖМЕНТИЙН СУРГАЛТ

Энэхүү сургалт нь хүний нөөцийн менежментийн талаар нэгдсэн ойлголтыг өгч, хүний нөөцийн бүрдүүлэлт, сургалт, хөгжил, стратеги, гүйцэтгэл, хөдөлмөрийн харилцааны талаар цэгцтэй ойлголтуудыг эзэмшүүлэхэд чиглэнэ.

Хүний нөөцийн менежментийн хүрээнд:

- Хүмүүсийг удирдах арга барил
- Хүний нөөцийн менежментийн суурь ойлголтууд
- Хүний нөөцийн менежментийн стратеги
- Байгууллагын тухай онол
- Ажлын байрны шинжилгээ
- Хүний нөөц бүрдүүлэлт
- Төрөлжилтийг удирдах
- Цалин хөлсний менежмент
- Хөдөлмөрийн харилцаа
- Үйлдвэрчний эвлэл ба тохиролцоо гэсэн чиглэлээр сургалтыг зохион байгуулж байна.

## 3. СУДАЛГААНЫ АРГАЗҮЙН СУРГАЛТ

Бид судалгаа, шинжилгээ хийх сонирхолтой хүн бүхэнд зориулан судалгааны аргазүйн сургалтыг зохион байгуулж байна. Судалгаа, шинжилгээний чиглэлээр мэргэшсэн эрдэмтэн багш нар хичээлийг удирдан явуулдаг бөгөөд судалгаа шинжилгээний орчин үеийн аргазүй, техникийг санал болгодог.

Судалгааны аргазүйн сургалтын хүрээнд дараах сургалтуудыг дангаар нь болон цогцоор нь санал болгож байна.

1. Судалгааны аргачлал ба дизайн боловсруулах
2. Судалгааны мэдээлэл цуглуулалт: Анхдагч ба хоёрдогч эх үүсвэрийн мэдээллийг хэрхэн цуглуулах, түүнийг шинжилгээнд хэрхэн бэлтгэх талаар зөвлөгөө
3. Судалгааны мэдээлэлд дүн шинжилгээ хийх
  - Баримт бичгийн шинжилгээ хийх аргазүй
  - Статистик шинжилгээ хийх аргазүй (SPSS, STATA, Eviews программ ашиглана)
  - Ахисан түвшний шинжилгээ хийх аргазүй
4. Үр дүнг нэгтгэж, эрдэм шинжилгээ, судалгааны өгүүлэл бичих аргазүй

# DATA МЕНЕЖМЕНТ

Бид **их өгөгдөлд** тулгуурласан судалгаа, зөвлөх үйлчилгээг хөгжүүлэхээр зорин ажиллаж байна. Энэ хүрээнд **өгөгдлийн санг бүрдүүлэх, их өгөгдөлд дүн шинжилгээ** хийх гэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Өгөгдлийн сан бүрдүүлэхдээ өгөгдлийн сангийн бүтэц, технологи, дэд бүтцийг хослуулан хөгжүүлэлт хийж байгаа бол өгөгдөлд дүн шинжилгээ хийхдээ орчин үеийн арга, загварчлал, үр чадвар, технологийг хослуулан ажиллаж байна.

Бид их өгөгдөлд тулгуурласан бизнесийн шийдвэр гаргалтыг дэмжих зөвлөх үйлчилгээг нэвтрүүлээд байна. Тодруулбал, өөрийн мэдээллийн санг бүрдүүлсэн ААНБ-уудын мэдээлэлд дүн шинжилгээ хийж, байгууллагын төлөвлөлт, шийдвэр гаргалтад чухал нөлөө бүхий үр дүнг боловсруулж байна.

Түүнчлэн манай компани оюуны бүтээлийн жинхэнэ байдлыг шалгах **ИНГҮМЭЛ платформыг** хөгжүүлдэг. Ингүмэл нь оюуны бүтээл, боловсролын зэрэг горилсон ажил, төрөл бүрийн бичвэрийг зохиогч өөрөө бичсэн эсэх, хэн нэгнээс эшлэл зүүлтгүйгээр хуулсан эсэхийг шалгадаг программ хангамж юм.

Ингүмэл платформын боломжууд:

**Мэдээллийн нэгдсэн сан:** Бүх түвшний эрдмийн ажил, зохиогчийн бүтээлийн нэгдсэн санг бүрдүүлэхийн зэрэгцээ эшлэлийн статистикийг боловсруулна.

**Давхардлыг илэрүүлж, эх сурвалжийг харуулах:** Аливаа бүтээлийг өөрийн нэгдсэн сан болон интернэт орчны эх сурвалжуудтай харьцуулж, давхардлыг тооцон үнэлгээ өгч, давхардсан эх сурвалжийн мэдээллийг харуулна.

**Интернэт орчны шуурхай найдвартай ажиллагаа:** Интернэт орчны вэб технологид суурилсан платформ учраас орон зай, цаг хугацаанаас үл хамааран ажиллана.



# БРЭНД СУДАЛГАА



Бид тогтмол үйл ажиллагаа бүхий МИРИМ-ийн өөрийн нэрийн судалгааг хөгжүүлж байна. Албан ёсны эх сурвалж бүхий нээлттэй мэдээллийн санд тулгуурлан **салбар болон зах зээлийн тойм судалгааг** тогтмол давтамжтайгаар боловсруулан олон нийтэд хүргэж эхэллээ.

“Таны бизнест зориулав” гэсэн шошготойгоор бизнес эрхлэгч, харилцагчиддаа зориулан тухайн зах зээлийн талаар таны бизнест хэрэг болохуйц шийдвэр гаргалт болон зах зээлийн байр сууриа нэмэгдүүлэхэд туслах үнэн бодит, системтэй мэдээллээр хангах, хамтдаа хөгжих, хамтран ажиллах боломжийг МИРИМ Консалтант бүрдүүлж байна.

Түүнчлэн бид **уул уурхайн хөрөнгө оруулалтын бодлогын орчны индексийг** тооцож, олон нийтэд хүргэж эхэллээ. Уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын талаарх төрийн бодлого, шийдвэр, үйл ажиллагааны үр дүн, өөрчлөлтийг хэмжиж, хөндлөнгийн байр сууринаас оролцогч талуудыг мэдээллээр хангах зорилготой.

Нүүрс, алт, зэсийн олборлолтын үйл ажиллагаа эрхэлдэг салбарын топ компаниудын удирдах албан тушаалтнуудаас судалгааны мэдээллийг цуглуулж, нийт 9 багц үзүүлэлтээр индексийг тооцож байна.



# МАНАЙ ХАРИЛЦАГЧИД

Бид 80+ захиалагчийн судалгаа, зөвлөх үйлчилгээг гүйцэтгэж, 10+ хамтрагч болон түншлэгч байгууллагуудтай хамтран ажиллаад байна.



Бид Европын сэргээн босголт хөгжлийн банкны (ЕСБХБ) “Жижиг дунд бизнесийн зөвлөх үйлчилгээ”-ний зөвлөх компани бөгөөд ЕСБХБ-ны тэтгэлгээр жижиг, дунд ААН-д 65 хүртэлх хувийн хөнгөлөлттэй үнээр зөвлөх үйлчилгээ үзүүлдэг



## ХАРИЛЦАГЧТАЙГАА ХАМТРАН АЖИЛЛАХДАА:

Харилцагчийнхаа хүсэл сонирхол, хэрэгцээ шаардлагад нийцсэн онцлог судалгаа болон зөвлөх үйлчилгээний аргачлалыг санал болгодог. Судалгааны эхлэлээс дуусах үе шат хүртэл бид захиалагчтайгаа нягт хамтарч ажилладагаараа онцлогтой. Бидний хамтын ажиллагаа тухайн үйлчилгээрээр хязгаарлагдахгүй бөгөөд урт хугацаанд бат бэх үргэлжлэх нөхцөл байдлыг бүрдүүлж, хэрэглэгчээ халамжлахыг бид зорьдог.



# БИДНИЙ ТҮҮХ



# МАНАЙ ХАМТ ОЛОН

Манай байгууллага салбар бүрийн мэргэшсэн 30+ зөвлөх, бизнесийн менежмент, эдийн засаг, загварчлал, санхүү, социологи, маркетинг, мэдээллийн технологи, инновацийн чиглэлээр мэргэшсэн 8 үндсэн ажилтан, 10+ гэрээт ажилтантайгаар үйл ажиллагаагаа эрхэлж байна.

Бид багаараа болон дангаараа олон улсын донор байгууллагууд, төрийн болон төрийн бус байгууллагууд, бизнес байгууллагуудын судалгаа, зөвлөх үйлчилгээ, сургалтын ажлуудыг амжилттай зохион байгуулж байсан. Манай зөвлөхүүд болон судлаачид Австрали, АНУ, Англи, Чех, Унгар, Турк, ОХУ-д боловсрол эзэмшиж, урт болон богино хугацааны мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдаж байв.

Бидний ажиллах зарчим багийн систем байдаг бөгөөд аливаа судалгаа, зөвлөх үйлчилгээг төслийн багаараа гүйцэтгэдэг. Төслийн баг багийн ахлагч, зохицуулагч, зөвлөхүүд, судлаачдаас бүрддэг. Манай компани нэгэн зэрэг 5-7 төслийг тогтмол хэрэгжүүлж байна.



Мэргэжлийн судалгаа • Бүтээлч гүйцэтгэл • Урт хугацааны түншлэл

MIRIM  
INNOVATION & CONSULTANT





(976)-70137012



contact@mirim.mn



Монгол улс, Улаанбаатар 14181,  
Сүхбаатар дүүрэг, 11-р хороо,  
ПроВан барилга, 15 давхар,  
1502 тоот



[www.mirim.mn](http://www.mirim.mn)



